

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 дүгээр
сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Дээрх дүрмийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын гүйцэтгэх захирал, дарга нарт үүрэг болгосугай

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН ХҮРЭЭНД ДУЛААН
ҮЙЛДВЭРЛЭХ, ТҮГЭЭХ, ДУЛААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ХООРОНДЫН ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТӨЛБӨРИЙН МӨНГӨНИЙ УРСГАЛЫГ ЗОХИЦУУЛАХ АЖ АХУЙН
ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аж ахуйн харилцааг “Дулааны нэг худалдан авагчтай” загварын дагуу зохицуулахтай холбогдуулан хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний төлбөрийн төвлөрсөн орлогын дүнгээс мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын данснуудад шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг урьдчилан тогтооход оршино.

1.2. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ /цаашид “ОСНААУГ” ОНӨААТҮГ гэх/ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан тус газрын дүрмийн 5.2 дахь заалтын дагуу энэ дүрмийн 1.1 дэх заалт хэрэгжинэ.

**Хоёр. Дулааны эрчим хүчний төлбөрийн
мөнгөний урсгалын зохицуулалт**

2.1. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК болон дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дулааны эрчим хүчний орлогын болон өөрийн үйл ажиллагааны бусад орлого, зардлын данстай байна.

2.2. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн дулааны эрчим хүчний төлбөрийг зөвхөн эрчим хүчний орлогын дансанд төвлөрүүлнэ.

2.3. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн төлсөн дулааны эрчим хүчний төлбөрийг 2.2-т заасан орлогын дансанд төвлөрүүлэх аж ахуйн гэрээг арилжааны банкуудтай байгуулж ажиллах ба энэхүү гэрээг Эрчим хүчний зохицуулах хороонд бүртгүүлнэ.

2.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний зохицуулах хороонд бүртгүүлсэн аж ахуйн гэрээнд заасан арилжааны банкна дахь орлогын данснаас бусад дансаар хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний төлбөрийн орлогыг төвлөрүүлэхийг хориглоно.

2.5. Хэрэглэгчдээс бэлнээр тооцож авсан дулааны эрчим хүчний төлбөрийг ажлын 1 хоногт багтаан орлогын дансанд тушаана.

2.6. Дулааны нэг худалдан авагчтай загварт хамрагддаг дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгал дараах байдлаар хэрэгжинэ.

2.6.1. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орлогын дансанд хэрэглэгчээс төлсөн эрчим хүчний төлбөрийг шуурхай төвлөрүүлэх зорилгоор арилжааны банкнуудтай "Шуурхай гүйлгээ хийлгэх үйлчилгээний тухай" аж ахуйн гэрээ байгуулж ажиллах бөгөөд энэхүү гэрээг Эрчим хүчний зохицуулах хороонд бүртгүүлнэ.

2.6.2. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх дулааны эрчим хүчний төлбөрийн орлого орсон тухай бүр урьдчилан тогтоосон хувь хэмжээгээр шуурхай гүйлгээ хийх, дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах тухай аж ахуйн гэрээг Эрчим хүчний зохицуулах хорооны зөвшөөрснөөр арилжааны банктай байгуулж ажиллах бөгөөд гэрээг Эрчим хүчний зохицуулах хороонд бүртгүүлнэ.

2.6.3. Арилжааны банктай байгуулсан гэрээний дагуу дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлогын дансанд төвлөрсөн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний төлбөрийг "Дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банк"-нд тусгайлан нээсэн “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн тэг үлдэгдэлтэй орлогын дансанд шуурхай шилжүүлнэ.

2.6.4. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн тэг үлдэгдэлтэй орлогын данснаас урьдчилан тогтоосон мөнгөний хувь хэмжээний дагуу мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банкнаас дахь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны зардлын данснүүдэд тус тус тухай бүр шуурхай гүйлгээ хийнэ.

2.6.5. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн "Дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банк"-нд тусгайлан нээсэн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас урьдчилан тогтоосон мөнгөний хувь хэмжээний дагуу үйлдвэрлэх болон Улаанбаатар дулааны сүлжээний өөрийн үйл ажиллагааны зардлын данснүүдэд тухай бүр шуурхай гүйлгээ хийнэ.

2.6.6. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь тэг үлдэгдэлтэй орлогын болон орлогын нэгдсэн данснаас дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын данснүүдэд шилжүүлэх мөнгөний хувь хэмжээг улирал бүр тус дүрмийн 3, 4 дэх хэсэгт заасан дүрмийн дагуу тооцож, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий албан ёсны төлөөлөгчдийг оролцуулсан "Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хурал"-аар хэлэлцүүлж, тэдгээрийн 70-аас доошгүй хувийн саналаар зөвшөөрсөн хувь хэмжээгээр тогтоох, хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санал 70 хувьд хүрэхгүй бол Эрчим хүчний зохицуулах хороонд хандаж шийдвэрлэнэ.

2.6.7. "Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хурал"-ыг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК зохион байгуулж хуралдуулах бөгөөд хурлыг тус сүлжээний санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан захирал удирдана. Хурлын тэмдэглэлийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК хөтөлнө.

2.6.8. "Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хурал"-ын шийдвэр нь бичгэн хэлбэртэй байх бөгөөд шийдвэрт хурал даргалагч болон тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.6.9. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь тэг үлдэгдэлтэй орлогын болон орлогын нэгдсэн данснаас эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч дулаан дүгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын данснүүдэд шилжүүлэх мөнгөний хувь хэмжээнд өөрчлөлт орсон тухай бүрт нь энэ талаар "Дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банк"-тай байгуулсан шуурхай гүйлгээ хийлгэх тухай үйлчилгээний аж ахуйн гэрээнд өөрчлөлт оруулж мөрдөнө.

2.6.10. Харилцан суутгах замаар хийх дулааны эрчим хүчний төлбөрийн тооцоонд дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өөрийн үйл ажиллагааны зардалд суутгасан мөнгөний дүнгийн эзлэх хувийн жин нь тэг үлдэгдэлтэй орлогын

болон орлогын нэгдсэн данснаас тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний хувь хэмжээнээс ихгүй байна.

2.6.11. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тайлангийн хугацаанд худалдан авсан дулааны эрчим хүчний төлбөрийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д илүү төвлөрүүлсэн тохиолдолд илүү төлсөн орлогын дүнг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд төлөх өрийн үлдэгдэлд харилцан суутгах замаар тооцож болно.

2.6.12. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай аж ахуйн гэрээ, дулааны эрчим хүчний төлбөрийн сарын эхний үлдэгдлийн тооцоо нийлсэн актыг үндэслэн тухайн тайлангийн хугацаанд тэг үлдэгдэлтэй орлогын данснаас тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд төвлөрүүлэх мөнгөний хэмжээг тогтоож, түүнээс давсан орлогыг өөрийн хуучин өр барагдуулах дансанд шилжүүлэх эрхтэй.

2.6.13. Дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дулаан үйлдвэрлэх болон дулаан түгээх, хангах тарифт өөрчлөлт орох тухай бүрт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлын данснудад шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээнд өөрчлөлт оруулж байна.

2.6.14. “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийг Эрчим хүчний зохицуулах хороо батална.

2.6.15. Энэхүү дүрмийн 2.6-д зааснаас бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрчим хүчний төлбөрийн мөнгөн урсгал худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулагдах ба эрчим хүчний төлбөр төлөх хуваарийг талууд харилцан тохиролцож гэрээнд тусгана.

2.7. “ОСНААУГ” ОНӨААТҮГ нь энэ дүрмийн 2.6 дахь заалтад хамаарагдахгүй бөгөөд эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгал дараах байдлаар хэрэгжинэ.

2.7.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 69 дугаар тогтоолын 3 удгаар хавсралтаар баталсан “Хангагч байгууллагууд болон “Орон сууцны нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, түгээх үйлчилгээ хийх аж ахуй нэгжүүдийн мөнгөний урсгалыг зохицуулах журам” болон энэ дүрмээр зохицуулагдана.

2.7.2. Энэ дүрмийн 2.7.1 дэх заалтыг хэрэгжүүлэхдээ сар бүрийн худалдан авсан дулааны эрчим хүчний хэмжээтэй тэнцэх өртгийг төвлөрүүлэх байдлаар мөнгөний хувь хэмжээг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай урьдчилан тохиролцоно.

2.7.3. “ОСНААУГ” ОНӨААТҮГ нь Улаанбаатар дулааны сүлжээтэй тохиролцсон мөнгөний хувь хэмжээг Эрчим хүчний зохицуулах хороогоор улирал бүр хянуулж дараа улирлын урьдчилсан тооцоог гаргана.

Гурав. Мөнгөний урсгалыг зохицуулах хувь хэмжээг тогтоох нөхцөл шаардлага

3.1. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн арилжааны банкинд байршуулсан “Орлогын данс”-нд хэрэглэгчдийн төлсөн дулааны эрчим хүчний төлбөрийг төвлөрүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн үйл ажиллагаанд ноогдох дулааны эрчим хүчний борлуулалтын орлогыг “Зардлын данс”-нд төвлөрүүлнэ.

3.3. Тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хэрэглэгчдэд худалдсан дулааны эрчим хүчний төлбөрийг төвлөрүүлэхээр эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банкинд нэг худалдан авагчтай загварыг зохицуулах дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Тэг үлдэгдэлтэй орлогын данс”-ыг нээнэ.

3.4. Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн худалдан авсан дулааны эрчим хүчний төлбөрийг төвлөрүүлэхээр эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулагч арилжааны банкинд нэг худалдан авагчтай загварыг зохицуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данс”-ыг нээнэ.

Дөрөв. Мөнгөний урсгалын хувь хэмжээг тогтоох

4.1. Тэг үлдэгдэлтэй орлогын дансаас тэг үдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$K_{\text{ТҮОД} \rightarrow \text{ТҮОНД}} = \frac{Q_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}} * T_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}} - \frac{\text{Хаалт}_{\text{ДТС} \rightarrow \text{НХА}}}{1.1}}{Q_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}} * T_{\text{хэр}} - \frac{\text{Хаалт}_{\text{ДТС} \rightarrow \text{НХА}}}{1.1}} * 100\%$$

Үүнээс:

$K_{\text{ТҮОД} \rightarrow \text{ТҮОНД}}$ – тухайн тэг үлдэгдэлтэй орлогын данснаас нэг худалдан авагчтай загварыг зохицуулах дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг;

$Q_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}}$ – “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид худалдах дулааны эрчим хүчний хэмжээг (Хэмжүүрээр худалдаж авсан дулааны эрчим хүчний биет хэмжээн дээр холбогдох дүрэм, журмын дагуу алдагдлын хэмжээг нэмж тооцно);

$T_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}}$ – “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид худалдах дулааны эрчим хүчний тарифыг;

$\text{Хаалт}_{\text{ДТС} \rightarrow \text{НХА}}$ – тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д төлөх худалдан авсан дулааны эрчим хүчний төлбөрийг суутган тооцоогоор хийх төмөр зам, төсөв, уурхайд ноогдох мөнгөний хэмжээг;

$T_{\text{хэр}}$ – Тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний дундаж тарифыг;

$$T_{\text{хэр}} = \frac{(\sum S_{\text{ахуй}} * T_{\text{халаалт}}^{\text{ахуй}} + \sum G_{\text{ахуй}} * T_{\text{ХХУ}}^{\text{ахуй}} + \sum \text{БО}_{\text{үйл.төл}}) + (\sum S_{\text{ААНБ}} * T_{\text{халаалт}}^{\text{ААНБ}} + \sum G_{\text{ААНБ}} * T_{\text{ХХУ}}^{\text{ААНБ}})}{Q_{\text{НХА} \rightarrow \text{ДТС}}}$$

Үүний:

$S_{\text{ахуй}}$ – Ахуйн хэрэглэгчийн халаалтын биет хэмжээ, тоо (Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифын ангилал тус бүрээр тооцож нийлбэрийг гаргана)

$T_{\text{халаалт}}^{\text{ахуй}}$ –Ахуйн хэрэглэгчдэд борлуулах халаалтын тариф (Эрчим хүчний зохицуулах хорооноос батлагдсан тариф)

$G_{\text{ахуй}}$ - Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулааны биет хэмжээ, тоо (Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифын ангилал тус бүрээр тооцож нийлбэрийг гаргана)

$T_{ХХУ}^{ахуй}$ - Ахуйн хэрэглэгчдэд борлуулах хэрэгцээний халуун ус халаасан дулааны тариф (Эрчим хүчний зохицуулах хорооноос батлагдсан тариф)

$BO_{үйл.төл}$ - Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф (Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифын ангилал тус бүрээр тооцож нийлбэрийг гаргана)

$S_{ААНБ}$ – Аж ахуй нэгж байгууллагын халаалтын биет хэмжээ, тоо (Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифын ангилал тус бүрээр тооцож нийлбэрийг гаргана)

$T_{халаалт}^{ААНБ}$ - Үйлдвэр аж ахуй нэгж байгууллагад борлуулах дулааны тариф (Эрчим хүчний зохицуулах хорооноос батлагдсан тариф)

$G_{ААНБ}$ - Аж ахуй нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулааны биет хэмжээ, тоо (Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифын ангилал тус бүрээр тооцож нийлбэрийг гаргана)

$T_{ХХУ}^{ААНБ}$ - Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулааны тариф (Эрчим хүчний зохицуулах хорооноос батлагдсан тариф)

Тэг үлдэгдэлтэй орлогын дансдаас тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$K_{ТҮОД \rightarrow ДТС} = 100\% - K_{ТҮОД \rightarrow ТҮОНД}$$

Үүнээс:

$K_{ТҮОД \rightarrow ДТС}$ – тухайн тэг үлдэгдэлтэй орлогын данснаас дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг;

4.2. Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд төвлөрсөн орлогын дүнгээс үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$K_{ТҮОНД \rightarrow ДЦС} = \frac{\left(Q_{ДЦС \rightarrow НХА} * T_{ДЦС \rightarrow НХА} - \frac{\text{Хаалт}_{НХА \rightarrow ДЦС}}{1.1} \right) * 100\%}{\sum (Q_{ДЦС \rightarrow НХА} * T_{ДЦС \rightarrow НХА}) + T_{УБДС}^{\text{тогтмол}} - \sum \frac{\text{Хаалт}_{НХА \rightarrow ДЦС}}{1.1}}$$

Үүнээс:

$K_{ТҮОНД \rightarrow ДЦС}$ – Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас тухайн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг;

$Q_{ДЦС \rightarrow НХА}$ – Тухайн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс Улаанбаатар дулааны сүлжээнд худалдах дулааны эрчим хүчний хэмжээг;

$T_{ДЦС \rightarrow НХА}$ – Тухайн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс Улаанбаатар дулааны сүлжээнд худалдах дулааны эрчим хүчний хэмжээг;

4.3. Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансанд төвлөрсөн орлогын дүнгээс “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$K_{ТҮОНД \rightarrow УБДС} = \frac{\left(T_{УБДС}^{\text{тогтмол}} - \frac{\text{Хаалт}_{НХА \rightarrow ДЦС}}{1.1} \right) * 100\%}{\sum (Q_{ДЦС \rightarrow НХА} * T_{ДЦС \rightarrow НХА}) + T_{УБДС}^{\text{тогтмол}} - \sum \frac{\text{Хаалт}_{НХА \rightarrow ДЦС}}{1.1}}$$

Үүнээс:

$K_{ТҮОНД \rightarrow УБДС}$ – Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн зардлын дансанд шилжүүлэх мөнгөний урсгалын хувь хэмжээг;

$Q_{\text{дцс} \rightarrow \text{нха}}$ – Тухайн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-д худалдах дулааны эрчим хүчний хэмжээг;

$T_{\text{УБДС}}^{\text{ТОГТМОЛ}}$ – “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн шугамын үйлчилгээний төлбөр;

4.4. Мөнгөний урсгалын хувь хэмжээг зууны нарийвчлалтайгаар тооцно

Тав. Бусад

5.1. Тухайн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчийн борлуулалтын орлогыг тооцож буй биет хэмжээ (талбай, эзэлхүүн, хэмжүүрээр тооцох дулаан, хүн.тоо, хэрэглээний халуун усны зарцуулалт, өрхийн тоо зэрэг...) бодитой тогтоогдсон эсэхэд “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас хяналт тавина.

5.2. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК болон дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд борлуулалтын орлого тооцож буй биет хэмжээтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Эрчим хүчний зохицуулах хороогоор хянуулж, дүгнэлт гаргуулна.

--- оОо ---